

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/54

Улаанбаатар хот

**Эрсдэлийн удирдлагын бодлогод
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 78 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоол, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Зохицуулагч байгууллагаас баталсан журамд Компанийн зохицуулалтын баримт бичиг болон үйл ажиллагааг нийцүүлэх зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу нэмэлт, өөрчлөлт орж буй “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/55

Улаанбаатар хот

Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 68 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 78 тоот “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тогтоол, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Зохицуулагч байгууллагаас баталсан журамд Компанийн зохицуулалтын баримт бичиг болон үйл ажиллагааг нийцүүлэх зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасны дагуу нэмэлт, өөрчлөлт орж буй “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/56

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 998 тоот тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компаниас гаргасан саналыг үндэслэн энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан хэмжээ бүхий чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдсон төлөгдөөгүй шимтгэл болон хүүгийн авлагын төлбөрийн хамт Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
2. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, тогтоомж болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
3. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааны гүйцэтгэлийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/57

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.12, 9.6.23 дахь заалт, Компанийн Үндсэн хөрөнгө, бараа материалын журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасан үндсэн хөрөнгүүдийг болон элэгдэл тооцож дуусаагүй боловч ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт **885,304.17** (найман зуун наян таван мянга гурван зуун дөрвөн төгрөг) төгрөгийн үлдэх өртөг бүхий энэхүү тогтоолын Хавсралт №2-т заасан үндсэн хөрөнгүүдийг тус тус акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Компанийн үндсэн хөрөнгийн комиссын хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгүүдийг акталж, данснаас хасаж, нягтлан бодох бүртгэлд зохих өөрчлөлт оруулах зэрэг ажлыг холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм журамд заасны дагуу зохион байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1, 73.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3.6, 9 дүгээр зүйлийн 9.6.13 дахь заалтууд болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”)-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хооронд зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. ХЭЭБХ-аар дараах асуудлуудыг шийдвэрлүүлэхээр оруулсугай.
 - а. “АНД Системс” ХХК-иас хоёрдогч өглөг хэлбэрээр Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх эсэх;
3. ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдэл”-ийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталж, “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ХК (“МХБ”)-д 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн дотор хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.
5. ХЭЭБХ-ыг зохион байгуулах тухай зарыг энэхүү тогтоолын Хавсралт №2-оор баталж, 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр болон 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрүүдэд МХБ-ийн цахим хуудас, Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, цахим орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийг хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын Хавсралт №3-аар баталж, баримт бичиг, саналын хуудсыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор бэлтгэн, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчид танилцах бололцоогоор хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын Хавсралт №3-т заасан баримт бичгийг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 16:00 цаг хүртэл Компанийн <https://lend.mn/> вэбсайт болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудаар дамжуулан танилцах боломжоор хангахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

8. ХЭЭБХ-ын Хурал зохион байгуулах комиссын даргаар Компанийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан захирал (Б.Оюунболд)-ыг томилж, комиссын бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын Хавсралт №4-ээр, Тооллогын комиссын даргаар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН-ийн партнер (С.Батбуян)-ыг томилж, тооллогын комиссын бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын Хавсралт №5-аар тус тус баталсугай.
9. ХЭЭБХ-ын эчнээ санал хураалтын саналын хуудсыг энэхүү тогтоолын Хавсралт №6-аар, ХЭЭБХ-ын эчнээ санал хураалтаар шийдвэрлүүлэхээр санал болгон оруулах хоёрдогч өглөгийн ерөнхий нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралт №7-оор тус тус баталсугай.
10. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлаар хувьцаа эзэмшигчдийн ирүүлсэн эчнээ санал хураалтын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комиссын дарга (Б.Оюунболд)-д үүрэг болгож, эчнээ саналын хуудсыг 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн хүлээн авч, эчнээ саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 16:00 цагаар тасалбар болгохоор тогтоосугай.
11. ХЭЭБХ-ын эчнээ санал хураалтын дүнгийн тайланг гаргаж, Компанийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлэхийг Тооллогын комисст үүрэг болгосугай.
12. ХЭЭБХ-ын даргаар Компанийн ТУЗ-ийн дарга (О.Болдбаатар)-ыг томилж, Тооллогын комиссын тайланг үндэслэн хурлын тогтоол гаргахыг Хурлын дарга (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.
13. ХЭЭБХ-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой гарах зардлын төсвийг баталж, санхүүжүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан), Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр

№ 25/59

Улаанбаатар хот

**Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх,
гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.23 дахь заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.
2. Улмаар Компани нь хөрөнгө оруулалтын платформын үйл ажиллагаа эрхэлдэг “KILDE Pte.Ltd.” (цаашид “Kilde” гэх)-аар төлөөлүүлсэн олон улсын хөрөнгө оруулагчид (цаашид “**Санхүүжүүлэгч тал**” гэх)-аас нийт 5,000,000 ам.долларын үнийн дүн бүхий санхүүжилт (цаашид “**Санхүүжилт**” гэх)-ийг зээлийн гэрээ (цаашид “**Зээлийн гэрээ**” гэх) байгуулах замаар татан төвлөрүүлэх тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.
3. Санхүүжилт татан төвлөрүүлэх үйл ажиллагааг баталгаажуулах хүрээнд Компаниас дор дурдсан санал ирүүлсэнтэй танилцаад:
 - 3.1. Санхүүжүүлэгч тал буюу ALT INCOME INVESTMENTS LMN1 PTE.LTD-тэй Зээлийн гэрээ байгуулах;
 - 3.2. Санхүүжүүлэгч талтай байгуулсан Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон ALT INCOME INVESTMENTS PTE.LTD-тэй Барьцааны гэрээ байгуулж, Санхүүжүүлэгч талын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулахаар барьцаалуулагчийн үүрэг хүлээх;

(цаашид хамтад нь “**Гэрээний багц**” гэх)
шаардлагатай байгааг тус тус тэмдэглэсүгэй.
4. Тус тогтоолын 3-т заасан Гэрээний багцыг байгуулах хүрээнд:
 - 4.1. Зээлийн гэрээний нөхцөлийг Хавсралт №1А-д зааснаар баталсугай.
 - 4.2. Барьцааны гэрээний нөхцөлийг Хавсралт №1Б-д зааснаар баталсугай.
5. Тус тогтоолын хавсралтаар батлагдсан Гэрээний багцыг байгуулан Санхүүжилт татан төвлөрүүлэхийг Компанид зөвшөөрсүгэй.
6. Гэрээний багцад багтаж буй гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, Багц гэрээний дагуу аливаа баримт бичиг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулах,

эдгээртэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.

7. Гэрээний багцыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Гэрээний багц түүнтэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

